

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН НБХ-ИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН О.БАТЦЭНГЭЛИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ ”							
1.	Арга хэмжээ 1.1. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлнэ.	Эрт илрүүлгийн хувь	85,5%	44.5%	2025 оны эхний хагас жилийн байдлаар зонхилон тохиолдох халдварт бус өвчний илрүүлгийг сайд засаг даргын гэрээнд тусгагдсанаар артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэгт зорилтот бүлгийн 75,1 хувь, чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлэгт зорилтот бүлгийн 92,7 хувь, хөхний өмөнгийн эрт илрүүлэгт 17626, умайн хүзүүний өмөнгийн илрүүлэгт зорилтот бүлгийн 43 хувийг тус тус хамруулхаар төлөвлөн илрүүлгийн дундаж хувь 58 % байна. Үүнд: - Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-с дээш насны нийт 24690 буюу хамрагдвал зохих хүн амын 51.9 хувийг эзэлж, өмнөх оноос (6.1) хувиар нэмэгдэж, үр дүнгийн үзүүлэлтээр 0.8 хувь нь онош батлагдсан. - Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 35-дээш насны 22577 буюу хамрагдвал зохих хүн амын 58,7 хувийг эзэлж, өмнөх оноос (22)	2025.01.01 2025.06.06	100%

					хувиар нэмэгдэж үр дүнгийн үзүүлэлтээр 0.3 хувь онош батлагдсан. - Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны 1876 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 71.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (20.6) хувиар нэмэгдсэн. Пап шинжилгээнд нийт 862 сорьц хүлээн авсан байна. - Хөхний эрт илрүүлэг үзлэгт 9249 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 49.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (7,8) хувиар өссөн байна.		
2.	Арга хэмжээ 1.2. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих “Эрүүл хамт олон” хөдөлгөөн өрнүүлж, сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулана	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	88	-	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аян хүрээнд Орхон аймгийн засаг даргын дэмжлэгтэйгээр шүд угаалтын уралдааныг 2023 оноос хойш 3 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд Энэ жил “ЗӨВИЙГ ДАДАЛ БОЛГОЁ” уриан дор “ШҮД, ГАР УГААЛТЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ УРАЛДААН”-ыг сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн дунд анх удаа зохион байгуулсан. Тус уралдаанд 2-5 насны хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчийн хамтаар оролцож байгаагаараа онцлог бөгөөд 31 цэцэрлэгийн 248 хүүхэд, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, Орхон аймгийн шүдний мэргэжилтний холбооны мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар, хүүхэд, асран хамгаалагчид гээд нийт 630 хүний оролцоотой зохион байгуулагдаж, гар угаах өртөө, шүд угаах өртөө, амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг шалгах тест бөглөх өртөө зэрэг 7 өртөөгөөр оролцогчдын мэдлэгийг үнэлэн эхний 5 байрыг шалгаруулан урамшуулсан. Шүүгчдийн дүнгээр 1-р байранд 1772 оноогоор 28-р цэцэрлэгийн “Найман шарга” баг 2-р байранд 1765 оноогоор 15-р цэцэрлэгийн “Танан” баг 2-р байранд 1745 оноогоор 20-р цэцэрлэгийн “Цахиурхан” баг 3-р байранд 1738 оноогоор Одод цэцэрлэгийн “Сүүн шүдхэн” баг	2025.01.01 2025.06.06	100%

					3-р байранд 1731 оноогоор Унага цэцэрлэгийн “Бяцхан шүд” баг тус тус байр эзэлсэн юм. Энэхүү шүд, гар угаалтын уралдааныг зохион байгуулснаар сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эцэг, эх асран хамгаалагчид, хүүхдүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, шүд гар угаах зөв аргачлалыг эзэмшүүлэх, хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах ач холболдолтой боллоо. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч 91 байгууллага байдаг.		
3.	Арга хэмжээ 1.3. Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэнэ	Дэмжлэгт хамрагдсан хорт хавдартай иргэдийн тоо	160	80	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 100.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс 2024 оны эхний 6 сарын байдлаар байдлаар аймгийн Засаг даргын 2025 оны А/123, дугаар захирамжаар 129 иргэнд 82,3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Эхний 5 сарын байдлаар хорт хавдрын 164 тохиолдол шинээр бүртгэгдэж 10 000 хүн амд 15.4 промилл, өмнөх оны мөн үеэс 5.3 промиллоор өссөн. Шинээр бүртгэгдсэн хорт хавдраас 26.2%-ийг элэгний хавдар, 17.7%-ийг ходоодны хавдар, 7.9%-ийг умайн хүзүүний өмөн, 6.7 %-ийг нойр булчирхайн хорт хавдар, 41.5%-ийг бусад хавдар эзэлж байна	2025.01.01 2025.06.06	100%
4	Арга хэмжээ 1.4. Эрүүл мэндийн ажилтны сургалт, нийгмийн асуудлыг дэмжих “Эмч” хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах, “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөр”-ийг	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	96%	40%	2021-2024 онд Эмч хөтөлбөрийн хүрээнд нийт 415.0 сая төгрөгийн төсвийг батлан хэрэгжилтийг зохион байгуулж, жил бүр нийт 2 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан. Хөтөлбөр 98.6% хэрэгжилттэй, шалгуур үзүүлэлт 97.8% ХШҮХ-ээр үнэлэгдлээ. Эмч хөтөлбөрийн хэрэгжилтийн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн хэрэгжилт “Хангалттай” үнэлгээгээр үнэлэгдэв. Эмч хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дуусгавар болж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03-р сарын 24-ний өдрийн 02/16 дугаар тогтоолоор “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулсан. Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөр”-	2025.01.01 2025.06.06	100%

	батлуулах, хэрэгжилтийг хангах				ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Монголын Хүүхдийн Анагаахын Академиас АШУҮИС-ийн АУС-ийн Хүүхдийн тэнхимтэй хамтран "Хүүхдэд зонхилон тохиолдох эмгэгүүд" "Хүүхдийн мэдрэл сэтгэцийн эмгэгүүд", "Хүүхдийн өвчний шинэчилсэн цогц менежмент" сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.Тус сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн төв, БОЭТ, Хүүхдийн клиникийн 40 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. Монгол улсын зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор Бямбаагийн Батбаяр агсны нэрэмжит амилуулах тусламжийн "Миний мэргэжил миний бахархал" ур чадварын тэмцээнийг 05 сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Тэмцээнд 25 ЭМБ-ын 33 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд сонгогдон 3 багт хуваагдан оролцсон. Шүүгчдийн дүнгээр Эрдэнэт медиал ТӨТМЭ, ХХЭМБ, Мөнхсүндрэл ӨЭМТ, Жаргалант сумын ЭМТ-үүдийн "AVENGERS" нэгдсэн баг шилдгээр шалгарч шагналаа гардан авсан.Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран "Амилуулах суурь тусламж" сэдэвт сургалтыг зохион байгуулж 300 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа. Өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох сургалт"-ыг зохион байгуулж сургууль, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 40 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. "Хойд бүс Эрдэнэт 2025" эдийн засгийн форумд нийгмийн салбарын 10 төслийг танилцуулахаар 5 баннер, 60 ширхэг төслийн карт,125 ширхэг боршур хийж оролцлоо. 24. Олон улсын сувилагч нарын баярын өдрийг тохиолдуулан "Эрдэм шинжилгээний бага хурал"-ыг зохион байгуулахад нийт 9 эрүүл мэндийн байгууллагын 65 судлаач сувилагч, тусгай мэргэжилтэний 15 илтгэлийг хэлэлцүүлж, шагналт байруудыг шалгаруулсан. Дэлхийн эмч нарын өдрийн тохиолдуулан эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдтийн дунд эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдлаа. Эрүүл мэндийн 13 байгууллагын 134 судлаач эмчийн 34 илтгэлийг		
--	--------------------------------------	--	--	--	--	--	--

					хэлэлцүүлж, нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламжийн чиглэлээр тус бүр 3 байр, ховор тохиолдлоор 2 байрыг шалгаруулж, урамшууллаа.		
5	Арга хэмжээ 1.5. Иргэдийн дунд авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэнэ	Цус цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн нөөцийг нэмэгдүүлэх хувь	96%	50%	Аймгийн Засаг даргын 2025 оны А/250 дугаар захирамжаар 10,0 сая төгрөгийг шийдвэрлэж, "Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе" уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвхи санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулж, 8 байгууллагын 287 донор цус бэлэглэж, 7 байгууллагын 142 хүнд донорын ач холбогдлыг таниулах мэдээлэл, сургалт сурталчилгаа хийгдсэн байна. Тайлант хугацаанд бүхэл цусны 403 донороос 403 нэгж цус цуглуулснаас байнгын 280 донороос 280 нэгж цус, шинэ 123 донороос 123 нэгж цус цуглуулсан байна. Нийт цус цуглуулалтын 68,1% суурин, 31,7% -ийг явуулын хэлбэрээр цуглуулсан байна. 2025 оны эхний 5 сарын байдлаар бүртгэлтэй байгаа 403 донорын цусны ABO, Резус бүлэг, Келл бүлэг, халдвар илрүүлэх шинжилгээнд 100% хамруулан баталгаажуулж, цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэл бүртгэгдээгүй байна. БОЭТ-ийн Цусны салбар төв нь 10 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бөгөөд цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл сүүлийн 3 жилийн эхний 5 сарын байдлаар авч үзвэл нийт үйлдвэрлэл 17%-аар өссөн буюу 1504 нэгж цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна.	2025.01.01 2025.06.06	100%
6	Арга хэмжээ 1.6. Суурь өвчтэй хүүхдүүдийг улирлын чанартай гэр сувилалд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэнэ	Суурь өвчтэй хүүхдийн эрүүлжсэн хувь	89%	-	Тайлант хугацаанд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр орон нутгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэн, сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нар ус агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулахаар сонгон шалгаруулалтыг Эрдэнэт мн сайтаар зарлаад байна.	2025.01.01 2025.06.06	Хугацаа болоогүй

					Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд сувиллын ээлжийн хуваарь, үнийн тариф, хоолны цэс, суурь өвчтэй хүүхдийг эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх, хамрагдах 5 хүртэл насны суурь өвчтэй хүүхдийн судалгааг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авах зэрэг ажлууд хийгдэж байна. 2025 оны эхний 5 сарын байдлаар тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад давхардсан тоогоор 39661 хүүхэд хамрагдсанаас 0.14 хувь нь туранхай, 0.15 хувь нь тураалтай, 0.28 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна. Суурь өвчтэй хүүхдүүдийг улирлын чанартай гэр сувилалд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх ажлын үр дүн 3-р улиралд гарна.		
7	Арга хэмжээ 1.7. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмд хамруулана	Аминдэмжүүл элтийн хангалтын хувь	15%	16%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 569 жирэмсэн, 639 эх төрсөн ба үүнээс нийгмийн халамж шаардлагатай цус багадалттай 295 жирэмсэн, хөхүүл эхчүүд байна. 2025 онд шинээр жирэмсний хяналтад орсон эхчүүдийн 4.8% нь цус багадалттай илэрсэн ба өмнөх оны мөн үеэс 3.5%-иар нэмэгдсэн байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/15 дүгээр тогтоол, Засаг даргын 2025 оны А/384 дугаар захирамж, Эрүүл мэндийн газрын даргын А/46 дугаар тушаалыг үндэслэн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр олон найрлагат 295 ширхэг Gentle Iron бэлдмэлийг татан авалтыг хийж, сум өрхийн эрүүл мэндийн 8 төвд 295 жирэмсэн, хөхүүл эхчүүд хуваарилан түгээсэн. Үр дүн нь 3-4 улиралд тооцож гаргана.	2025.01.01 2025.06.06	100%
Зорилт 2. “Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна							
8	Арга хэмжээ 2.1. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж, өрхийн	Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг жилд 2	90,3%		Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/122 тоот тушаалын дагуу Засаг даргын А/252 дугаар захирамжаар гэрээний гүйцэтгэлийг үнэлэх “Үнэлгээний баг”-ийг шинэчлэн баталсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй Засаг Дарга, Эрүүл мэндийн газрын дарга хамтран ажиллах гэрээг байгуулсан. 8 өрхийн эрүүл мэндийн төвтэй	2025.01.01 2025.06.06	Хугацаа болоогүй

	эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавьж, ЭМЯ-д хүргүүлэнэ	удаа дүгнэх, дундаж хувь		91,5%	гүйцэтгэлийн гэрээг аймгийн Засаг даргын А/253 дугаар захирамжийн дагуу байгуулагдсан үнэлгээний баг гэрээний гүйцэтгэлд үнэлгээг 6-р сарын 9-13-ны хооронд хийхээр бэлтгэл ажил хангаж байна. Тайлант хугацаанд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 135,086 үзлэг хийгдэж өмнөх оны мөн үеэс 8,182 тохиолдлоор нэмэгдсэн. - Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 53.7% болж өмнөх оны мөн үеэс 0.3%-иар нэмэгдсэн. - Гэрийн идэвхтэй эргэлтийг 41,096 удаа үзүүлж өмнөх оны мөн үеэс 1898 тохиолдлоор нэмэгдэж, 2065 өвчлөл шинээр бүртгэгдсэн. - Явуулын, түр оршин суугч 4570 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлсэн. - Диспансерын хяналтад 8058 өвчтөн хянагдаж байгаагаас цусны даралт ихсэлт – 2033 (25.2%), гепатит – 1279 (15.8%), чихрийн шижин – 1036 (12.8%), хорт хавдар – 622 (7.7%) байна. Эдгээрээс тайлант хугацаанд 762 өвчтнийг шинээр хяналтад авч 286 (37.5%) эдгэрсэн, 214 (28%) шилжсэн, 40 (5.2%) нас барсан байна. Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд 2 удаа дэмжлэгт хяналт хийсэн		
9	Арга хэмжээ 2.2. Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжийг засварлан, тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана.	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	90,9%	92%	Өрхийн эрүүл мэндийн 8 төв нь 11 салбартай үйл ажиллагаа явуулж байгаагаас 4 нь цогц төвийн барилгатай, 2 нь эрүүл мэндийн үйлчилгээний зориулалттай байранд, 5 нь багийн нэгдсэн байранд тусламж үйлчилгээ үзүүлж байна.Үйлсбадрах ӨЭМТ-ийн цогц төвийн барилга барих 3,4 тэрбум төгрөг улсын төсөвт суугдсан. Тайлант хугацаанд барилгын засвар, үйлчилгээний чиглэлээр ОНТ-өөс 449,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс Мэндцэцэн ӨЭМТ-ийн гадна шугамыг засварлах 196,7 сая төгрөгийн ажил хийгдсэн. Анхны Оч ӨЭМТ-ийн дээврийн болон дотор засварт 253 сая төгрөг батлагдан 2025 оны 6-р сард гүйцэтгэж дуусахаар засварын ажил хийгдсэн. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийн хангалт 96%-тэй байна. Тайлант хугацаанд тоног төхөөрөмжийн	2025.01.01 2025.06.06	100%

					хангалтыг сайжруулах чиглэлээр нийт 75 сая төгрөгний санхүүжилт Баян-Өндөр ИТХ-ээс олгосон ба үүнд: - Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвд гэрийн эргэлтэд шаардлагатай 25 сая төгрөгний үнэлгээ бүхий prius 30 автомашин, 30 сая төгрөгний санхүүжилтээр мобайл тусламжийн аппаратыг ОНӨГ хүлээлгэн өгсөн. - ӨЭМТ-үүдэд 40 сая төгрөгний санхүүжилтээр хавдарын маркер үзэх, урвалж оношлуураар хангаснаас ӨЭМТ-д хавдрын маркер, триглицерид, липид, иммунологийн шинжилгээ /CRP, TSH, Витамин Д, Глюкозжсон гемоглобин/ зэрэг шинжилгээний үзүүлэлтээр тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн. Тайлант онд цаашид ОНТ-өөс 17 сая төгрөгийн санхүүжилтээр 2 шарлагын аппарат, 33 сая төгрөгийн санхүүжилтээр 1 цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат нийт 50 сая төгрөгний санхүүжилтээр тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах ажил хийгдэхээр төсөвлөгдсөн байгаа		
10	Арга хэмжээ 2.3. БОЭТ-ийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломж бүрдүүлнэ.	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	93,5%	50%	Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь стандартын дагуу нэн шаардлагатай болон шаардлагатай 600 гаруй багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн багаж тоног төхөөрөмжийн эзлэх хувь 20,1%-тай байна. Тайлант хугацаанд тусламж үйлчилгээнд шаардлагатай 300,0 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж, улсын төсвөөр 4 тэрбум төгрөгөөр MRI худалдан авах тендерүүд зарлагдсан байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 602.0 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96 хувьтай байна.	2025.01.01 2025.06.06	100%

11	Арга хэмжээ 2.4. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд цаг товллол болон түргэн тусламжийн 103 дуудлагыг цахимжуулалтын программ хангамжийн зардлыг шийдвэрлүүлнэ	Программ хангамжийн зардал шийдвэрлэгдсэн байна.	-	50%	Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь цаг товллол болон түргэн тусламжийн 103 дуудлагыг цахимжуулалтын программ хангамжийн сайжруулах зорилгоор орон нутгийн 70,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Egosoft” ХХК-тай 2025 оны 2 сарын 14-ны өдөр ажил гүйцэтгүүлэх гэрээ хийсэн байна. Одоогоор ажлыг гүйцэтгэл 97,8%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байгаа бөгөөд гэрээнд тусгагдсны дагуу 2025 оны 6 сарын 30-ны өдөр хүлээлгэж өгөхөөр төлөвлөсөн байна	2025.01.01 2025.06.06	100%
12	Арга хэмжээ 2.5. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж “Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төв” байгуулна	Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо	70	50	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хавдрын оношилгоо эмчилгээ хяналт сэргийлэлтийн цогц төвийг 2025 онд өргөтгөн 6 өрөө бүхий нийт 200 м2 үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсэг, үзлэг оношилгоо хийх, хими эмчилгээ, хавдрын бүртгэл мэдээллийн хэсгийг байгуулж, үйлчлүүлэгчдэд ээлтэй тав тухтай орчныг бүрдүүлсэн. Орон нутгийн 350 сая төгрөгийн санхүүжилтээр тус төвийн их засварын ажил хийгдэхээр тусгагдсан. Эмгэг судлалын оношилгоо, гестологи, эсийн шинжилгээний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор улсын төсвөөс 800 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн багц тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлж, суурилуулагдан оношилгооны чадавхи нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд тус төвөөр нийт 1092 үзлэг хийгдсэнээс өвчний учир эмнэлэгт хандан хавдар оношлогдсон 113 /78,4/, эрт илрүүлгээр хавдар илэрсэн 31 /21,5%/ хүн үүнээс хавдрын төвөөр оношлогдсон 5, диспансерын хяналтад 1540 иргэн байна. Нийт хавдрын 44,4 хувь нь эрт үедээ, 55,5 хувь нь хожуу үедээ оношлогдсон. 2025 оны эхний 5 сарын байдлаар хорт хавдрын 144 тохиолдол шинээр бүртгэгдэж 10 000 хүн амд 13.5 промилл, өмнөх оны мөн үеэс 61 тохиолдол буюу 5.6 промиллоор өссөн байна. Хойд бүсийн форумаас “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Эрдэнэт медиал төрөлжсөн эмнэлгийг Хавдрын	2025.01.01 2025.06.06	100%

					үндэсний төв эмнэлгийн салбар эмнэлэг болгон бүсийн хэмжээнд хавдрын тусламж үйлчилгээн дэх төвлөрөл, хүлээгдлийг бууруулж өргөжүүлэх шийдвэрийг гаргасан байна.		
13	Арга хэмжээ 2.6. БОЭТ-ийн төрөх тасгийн засварыг хийж, стандартын шаардлага хангасан тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ	Засвар хийгдсэн байна	-	20%	БОЭТ-ийн төрөх тасгийн засвар үйлчилгээний зардалд орон нутгийн төсвөөс 1 тэрбум 235 сая төгрөгийн тендэр зарлагдсан байна. Ингэснээр БОЭТ-ийн төрөх тасгийн 1,2,3,4 давхарт хуваарийн дагуу их засвар хийгдэж, эх хүүхдэд ээлтэй орчинг бүрдэнэ.	2025.01.01 2025.06.06	70%
Зорилт 3. “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах”							
14	Арга хэмжээ 3.1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааны ил тод байдлыг хангах	Хурлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95%	50%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажилгаа эрхлэх чиглэлээр Тусгай зөвшөөрөл олгох хурлыг нийт 5 удаа хуралдуулж 26 байгууллагын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд сунгалт 4, эрх сэргээлгэсэн 1, түдгэлзүүлсэн 6, хүчингүй болгосон 5, хаягийн шилжилт 2, төсөл 4, шинээр 4 байгууллагад зөвшөөрөл олгосон. Ажлын байранд үнэлгээ хийх удирдамжийн дагуу 5 удаагийн үнэлгээг хийж, тусгай зөвшөөрлийн хурлаар дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 72 эмийн санд хяналт үнэлгээ хийсэн. Мөн батлагдсан удирдамжийн дагуу эм, био бэлдмэлийн улсын байцаагчтай хамтран сургалт, мэдээллийг 70 эм зүйч, эм найруулагч нарт зохион байгуулсан. Цахим хөгжлийн яамнаас ирүүлсэн мэдээллийн дагуу ЗДТГ-ын ХЭЗХ-т тусгай зөвшөөрлийн талаарх 3 чиглэлийн мэдээллийг гарган хүргүүлсэн. Мэдээллийн нэгдсэн цахим програм(license)-ын	2025.01.01 2025.06.06	100%

					санал, ЭМЯ-нд тусгай зөвшөөрөл олгох, Зөвшөөрлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой 11 саналыг нэгтгэж хугацаанд нь хүргүүлсэн.Тусгай зөвшөөрлийн хүрээнд хаягийн шилжилттэй холбоотой 2 иргэний гомдолыг эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн хамт ажлын байранд 4 удаагийн хяналтыг хийж шийдвэрлэсэн байна.		
15	Арга хэмжээ 3.2 Эмнэлгүүдийг магадлан итгэмжлэлд хамруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Батлагдсан хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт	90%	50%	Тайлант хугацаанд магадлан итгэмжлэлд хамрагдсан 25 байгууллага байгаагаас анхан шатлалд 9 байгууллага 100%, 2 дахь шатлалд 4 байгууллага 100%, ор бүхий клиникийн 11 буюу 91,6%, оргүй клиник 1 буюу 1,8% -ийг эзэлж байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Эрдэнэт медиал төрөлжсөн эмнэлэг, Эрдэнэт клиник магадлан итгэмжлэлийн 36 шалгуур материалыг bakend .acc.hdc.gov.mn программд оруулан ЭМХТөвийн эхний шатны үнэлгээнд тэнцэж, 2 дахь шатны магадлангийн шинжээчдийн үнэлгээнд орох бэлтгэл хангаж байна. Магадлан итгэмжлэлд хамрагдсан улс болон хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагууд чанар аюулгүй байдлыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг 7 зорилтын хүрээнд батлуулан хэрэгжүүлж, хэрэгжилт дунджаар 90,4%-тай үнэлэгдсэн.Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж,Чанар аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр,төлөвлөгөөний хэрэгжилт, Эмчилгээ чанарын албад, багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 2 удаа, сургалт мэдээлэл 3 удаа хийж, “Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулая” 2 сарын аяныг зарлан үйлчлүүлэгчдэд ээлтэй аюулгүй орчинг бүрдүүлэх, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг	2025.01.01 2025.06.06	100%

					сайжруулах сургалт, туршлага солилцох уулзалт, өдөрлөгийг 2 удаа зохион байгуулсан.		
16	Арга хэмжээ 3.3. ISO:2015 стандартыг 5 өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нэвтрүүлэх зардлыг шийдвэрлэх	Чанарын ISO 9001-2015 стандарт нэвтэрсэн байгууллагын тоо	3	40%	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/15 дүгээр тогтоолын дагуу БОЭТ, 5 ӨЭМТ-д чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэхэд 20 сая төгрөг батлагдсан. Үүний дагуу Олон Улсын чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг 5 өрхийн эрүүл мэндийн төв World Standard Consulting ХХК-тай гэрээлэн нэвтрүүлж, эрүүл мэндийн салбарын ажиллагсад нийт 100 гаруй хүнд “Үр нөлөөний тайлан”-г Залуучуудын ордонд танилцуулсан. Стандартыг нэвтрүүлэх ажилд 5 өрхийн эрүүл мэндийн төвөөс 10 шинэ дотоод аудитор, БОЭТ-өөс 3 дотоод аудитор нийт 13 дотоод аудитор бэлтгэгдсэн ба 5 өрхийн эрүүл мэндийн төв 2025 оны 6-р сарын 9- 13-ны өдрүүдэд “Мон Cerf”ХХК тохирлын үнэлгээний байгууллагатай хамтран баталгаажуулах аудитад хамрагдаж гэрчилгээ авахаар төлөвлөн ажиллаж байна	2025.01.01 2025.06.06	100%
17	Арга хэмжээ 3.4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Үндэсний багийн орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол,	Үндэсний багт үзүүлсэн иргэдийн тоо	100	50	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан Төвлөрлийг бууруулах эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүлээгдлийг бууруулах чиглэлээр Үндэсний баг Орхон аймагт 2 удаа ажиллан нийт 682 иргэнд үзлэг хийгдсэн. Үүнээс 2 хүнд элэгний хавдрын судас бөглөх эмчилгээ, 3 хүнд элэгний хавдрын мэс засал, 30 хүнд хөхний үзлэг, оношилгоо хийж 3 хүнд хөхний мэс засал хийгдсэн. Хавдрын оношилгоо, эмчилгээ,хяналт сэргийлэлтийн төвийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр БОЭТ-ийн хавдар болон мэс заслын чиглэлээр нийт 3 эмчийг ХСҮТ-д нарийн мэргэжлийн сургалтад хамруулан хүний нөөцийг	2025.01.01 2025.06.06	100%

	унааны зардлыг шийдвэрлэх				чадавхжуулсан.Үндэсний багийн орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр,хоол,унааны зардалд орон нутгийн төсвөөс 25,8 сая төгрөгийг шийдвэрлэсэн		
Зорилт 4. “Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах ”							
18	Арга хэмжээ 4.1. ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь	100%	50%	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг тогтоосон хугацаанд гарган өгч ажиллалаа. 2025 оны эхний хагас жилд чиг үүргийн дагуу ирсэн 28 албан бичгийн хугацаанд нь шийдвэрлэн хааж, харьяа агентлагиудад чиглэл өгсөн 13 албан бичгийг хүргүүлэн ажилласан байна	2025.01.01 2025.06.06	100%
19	Арга хэмжээ 4.2. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо	150	60	Иргэдээс ирүүлсэн 146 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэв	2025.01.01 2025.06.06	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/Д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх	Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо	Шийдвэрийн дагуу ажиллах	Шийдвэрийн дагуу ажиллах	Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллаж, удирдлага болон ЗДТГ-ын албан хаагчдын хурлаас өгөгдсөн нийт 33 үүрэг даалгавар, хэлтсийн даргаас өгөгдсөн 10 үүрэг даалгаврын биелэлт 99,6%-тай шуурхай шийдвэрлэн гүйцэтгэн ажиллалаа.	2025.01.01 2025.06.06	100%
2	Шийдвэрлэсэн албан бичиг	Албан бичгийн тоо	Албан бичгийн шийдвэрлэж хариуг өгсөн байх	Албан бичгийн шийдвэрлэж хариуг өгсөн байх	Ирүүлсэн нийт 28 албан бичгийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэв	2025.01.01 2025.06.06	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/Д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1	Арга хэмжээ 1. Байгууллагын зүгээс зохион байгуулсан сургалт үйл ажиллагаанд хамрагдах	Өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдсан байна.	4	Ажил үүргийн холбогдолтой сургалт үйл ажиллагаанд хамрагдах	1.“Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” хойд бүсийн зөвлөгөө 2.Аймгийн ИТХ-ын Нийгмийн хөгжлийн хорооноос зохион байгуулсан "Архины хамааралтай хүнд үзүүлэх сэтгэц-нийгмийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах" сургалтад хамрагдлаа.	2025.01.01 2025.06.06	100%

2	Арга хэмжээ 2. Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах	-Сургалтуудад хамрагдсан байна.	4	Ажил үүргийн холбогдолтой сургалт үйл ажиллагаанд хамрагдах	1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсгэдэг халдварт өвчний цар тахлын үеийн тусламж үйлчилгээг хүний эрхийн хандлагад нийцүүлэн үзүүлэх нь" сэдэвт сургалт 2. Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэгтэй хамтран "Амилуулах суурь тусламж"-ийн сургалт 3. "Хойд бүс Эрдэнэт 2025" эдийн засгийн форум 4. "Төрийн албаны манлайлал" сургалт 5. ХАБЭА-н талаарх мэдлэг, ажлын байрны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим чиглэлийн сургалт 6. Гамшгийн эрсдлийг бууруулахад орон нутгийн эмэгтэйчүүдийн оролцоо-III" сургалтад хамрагдлаа.	2025.01.01 2025.06.06	100%
---	---	---------------------------------------	---	---	---	--------------------------	------

НБХ-ийн мэргэжилтэн
(Албан тушаал)

ТАЙЛАН ГАРГАСАН:

О.Батцэнгэл /
(Нэр, гарын үсэг)

2025.06.05
(Огноо)

